

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2024.03.05

Булган аймаг


**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны XIII хуралдааны XIII/02 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2023 оны А/138 дугаар захирамжаар хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тус тус өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. Тус хөтөлбөр, төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.


Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 36 хавсралтын дагуу гаргасан тайланд бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцох аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 103 зорилтын хэрэгжилтэд 2024 оны байдлаар өссөн дүнгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтын хэрэгжилт 91.9 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.




Хүний хөгжлийн бодлогын 29 зорилт 95.3 хувь, эдийн засгийн бодлогын 22 зорилт 92.3 хувь, ногоон хөгжлийн бодлогын 22 зорилт 91.0 хувь, засаглалын бодлогын 20 зорилт 92.4 хувь, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 10 зорилт 88.5 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд 45 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 52 зорилт 70.0-100 хүртэл хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 6 зорилт 30.0-70.0 хүртэл хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай байна.



Тус хөтөлбөрийн 2 зорилтын хэрэгжилт 30.0 хувь, 1 зорилтын хэрэгжилт 50.0 хувийн хэрэгжилттэй байгаа ба энэхүү зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд бэлтгэл ажил хийгдсэн, дээд шатны байгууллагад хүсэлтээ уламжилсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй зэргээс шалтгаалан хэрэгжилт нь удааширчээ.

Дээрх 103 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 259 арга хэмжээнээс 168 арга хэмжээ 100 хувь, 52 арга хэмжээ 90.0 хувь, 22 арга хэмжээ 70.0 хувь, 6 арга хэмжээ 50.0 хувь, 10 арга хэмжээ 30.0 хувь, 1 арга хэмжээ 0 хувийн хэрэгжилттэй байна.



Энэхүү төлөвлөгөөнөөс тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн болон ажлын гүйцэтгэлээр нь 6 арга хэмжээг 50.0 хувиар, бэлтгэл ажлыг хангасан, холбогдох байгууллагад санал уламжилсан болон ажлын гүйцэтгэлээр нь 10 арга хэмжээг 30.0 хувиар, 1 арга хэмжээг 0 хувиар тус тус дүгнэлээ. Хөрөнгийн эх үүсвэргүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байгаа зэрэг шалтгаанаас зарим арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:

1.1.1.2. Сумдын Эрүүл мэндийн төвд стандартын шаардлага хангасан моргийн барилга шинээр барих;

2.2.1.2. Стандартын шаардлага хангасан МЭАЦ-ийн лаборатори, Орхон, суманд мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний төвийн ажлыг эхлүүлэх;

2.2.2.4. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ хэрчих, хатаах тоног төхөөрөмжийг нийлүүлэх;

2.2.2.5. Зөгийн бал ялгаж савлах цех, тоног төхөөрөмжийн хамтаар нийлүүлэх;

2.2.10.2. Булган суманд 1000 м.кв бүхий өвлийн хүлэмж байгуулах;

2.2.11.1. Булган, Хутаг-Өндөр суманд тус бүр 500 тоннын багтаамжтай механикжсан зоорь барих;

2.3.4.5. Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж, хөгжүүлэх;

3.1.1.2. Баяннуур сумын “Баян” нуурыг сэргээх;

3.1.1.5. Хөв цөөрөм байгуулж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;

3.3.3.3. Улс, орон нутгийн чанартай авто зам барихад шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах түр зөвшөөрөл олгосон карьерын нөхөн сэргээлтийг хүлээж авах;

3.4.4.1. Аймгийн Хүүхэд, залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөг Булган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчилж, тохижилтийн ажлыг үе шаттайгаар гүйцэтгэх;

3.4.7.1. Булган сумын 6 дугаар багийн “Д” хэсгийн 3.2 км авто замыг барих;

3.4.9.1. Бага оврын агаарын хөлгийн нислэгийг тогтмолжуулах;

4.3.6.1. Төрийн Архивын баримтыг зориулалтын стандартын шаардлага хангасан байранд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх;

4.3.11.4. Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг эмнэлгийн байртай болгох;

5.1.2.1. "Булган үйлдвэр технологийн төв"-д гадаад дотоодын хөрөнгө оруулалт татаж, эхний ээлжинд 1100 тн ноос угаах үйлдвэр болон мах боловсруулах үйлдвэр байгуулах хөрөнгө оруулагчийг бодлогоор дэмжих;

5.1.4.1. Булган суманд ажлын зураг төсөл нь бэлэн байгаа үерийн сувгуудын ажлыг хэрэгжүүлэх;

Тухайлбал дээрх хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 15 нь төсөв хөрөнгөгүй, 2 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.

### **Гурав. Дүгнэлт**

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, үнэлэн дараах дүгнэлтийг хийлээ.

- 2021-2024 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн зорилт, арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжжээ.
- Нийт зорилтын 94.2 хувь, арга хэмжээний 93.4 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй болон энэ оны төсөвт тусгагдаагүйгээс шалгаалж зарим ажлууд удааширсан байна. Тухайлбал дээрх хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 15 нь төсөв хөрөнгөгүй, 2 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.

### **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/**

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу судалгаа, шинжилгээнд үндэслэх зарчмын хүрээнд тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, үе шат, хэрэгжих хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, гарах үр дүн, тулгамдаж байгаа асуудал зэргийг нарийвчлан судалж, судалгааны үр дүнг төлөвлөлтөд ашиглаж хэвших;
- Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог хангах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах;

- Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэх;
- Сумын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлаг, байгууллагууд үйл явцыг бус гүйцэтгэл, үр дүн, хүрсэн түвшний талаар тайлагнаж, тухайн зорилт, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тусгаж, хүрсэн түвшнийг илтгэх холбогдох баримт нотолгоог хавсаргаж ([bulgan.igovernment.mn](http://bulgan.igovernment.mn)) тайлагнах;
- Сум, байгууллагын түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч, нэгдсэн ойлголтод хүрэх, харилцан уялдаатай нягт хамтран ажиллах;

#### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС